НЗО-ны 1993 оны А282-р захирамжаар хүчингүй.

ТҮЛШ ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮЙЛДВЭРИЙН ЯАМ,
УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ХАМТАРСАН ХУРЛЫН ТОГТООЛ

1982 оны 9 дугаар сарын 23-ны өдөр

Дугаар 22/205

Улаанбаатар хот

ГЭРИЙН ХОРООД, ОРОН СУУЦНЫ ДОТОР ТАЛЫН ЦАХИЛГААН ХАНГАМЖИД ГАРСАН ЖИЖИГ ГЭМТЛИЙГ ЗАСВАРЛАХ ТАСАГ БАЙГУУЛАХ ТУХАЙ

Гэрийн хороод, орон сууцны байшингийн дотор талын цахилгаан хангамжийн үйлчилгээг хөдөлмөрчдөд ойртуулан сайжруулах талаар гарсан БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1969 оны 33-р тогтоол, 1981 оны 43 тоот албан даалгавар, БНМАУ-ын Хөдөлмөр нийгэм хангамжийн улсын хорооны 1982 оны 187-р тогтоолыг хэрэгжүүлэх үндсэн дээр ТОГТООХ нь:

1. Гэрийн хороод, орон сууцны байшингийн дотор талын цахилгаан хангамжид гарсан жижиг гэмтэл, саатлыг засварлах үүрэг бүхий засварын тасгийг Улаанбаатар хотын Сүхбаатар, Октябрь, Ажилчин, Найрамдал, Багануурын районд байгуулан Цахилгаан шугам сүлжээний газрын харъяаллын дор 1982 оны 10-р сарын 1-нээс эхлэн аж ахуйн дотоод тооцооны үндсэн дээр ажиллуулсугай.

2. Шинээр байгуулах тасгийн зохион байгуулалт, ажиллах журам, зардал, үйлдвэрлэлийн даалгаврыг боловсруулан баталж, гүйцэтгэлд нь тогтмол хяналт тавьж ажиллуулахыг Цахилгаан шугам сүлжээний газар /н.Хатанбаатар/-т үүрэг болгосугай.

3. Хавсралтанд заасан байруудыг 1982 оны 10 дугаар сарын 1-ний дотор засвар үйлчилгээний тасгийг байрлуулахад зориулан чөлөөлж өгөхийг районуудын АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга нарт даалгасугай.

4. Засвар-үйлчилгээний тасгуудын контórт утсан холбоо тавьж өгөхийг Телефон радио ашиглалтын хороо /н.Баатар/-т үүрэг болгосугай.

ТҮЛШ ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ САЙД П.ОЧИРБАТ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА С.МӨНХЖАРГАЛ

Түлш эрчим хүчний үйлдвэрийн яам, Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны хамтарсан хурлын 1982 оны ____ дугаар тогтоолын хавсралт.

## ЦАХИЛГААНЫ ЗАСВАР-ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАСГИЙГ БАЙРЛУУЛАХ БАЙР.

| № | районы нэр | гарын байр | Одоо хэний мэдэлд байгаа | Байр гаргаж өгөх асуудлыг хариуцах хүн |
|---|---|---|---|---|
| I. | Ажилчин | Хуучин Яармагийн хүүхдийн цэцэрлэг байсан дан шавар байшин | Ажилчны районы АДХГ захиргаа | Ойдовсамбуу |
| 2. | Октябрь | ОСТ-ны I8-р хорооны улаан булан | Октябрийн районы АДХГ захиргаа | Гунгаажав |
| 3. | Найрамдал | ~~[illegible] районы сууцанд байрлаж байгаа хүүхдийн хэсгийн 3 өрөө~~ байр. Найрамдалын районы 30-р сургууль | Хотын эрүүлийг хамгаалах газар | Тогоо Бямбаа |
| 4. | Сүхбаатар | I 40000-ын 3-р байрын 4-р орцны подвал | ОСА-ын I-р контор | Цэдэв Батжаргал |

Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны 1982 оны 204 дугаар тогтоолоор батлав.

# ХОТЫН АДХ-ЫН 13 ДАХЬ УДААГИЙН Y ЧУУЛГАНЫГ УГТАЖ ЗОХИОХ БЭЛТГЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

## НЭГ. Чуулган угтаж зохиох ажлын талаар

1. Улаанбаатар хотын АДХ-ын Y чуулган угтаж худалдаа нийтийн хоолны газруудын төлөвлөгөөг биелүүлэх, үйлчилгээний чанар, соёлч байдлыг дээшлүүлэх 3 долоо хоногийн ажил зохиож дүнг чуулганд рапортлах ажил зохиох талаар худалдааны контор, нийтийн хоолны трестийн дарга нарын семинар хийх.

6/X-аас Шагдар, Баатаржав

2. Хотын худалдааны жижиглэн худалдаалах цэгүүд дээр үйлчилгээний соёлч байдал, ариун цэвэр, тоног төхөөрөмжийн ашиглалт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд 3 шатны хурлын депутатын үзлэгийг явуулах.

9-р сарын сүүлийн 7 хоногт

3. Хөдөлмөрчдийн эрэлт, хэрэгцээг хангах, үйлчилгээг хөнгөн шуурхай, соёлч боловсон болгох талаар зохиож байгаа ажлын тухай худалдаа, нийтийн хоолны удирдах газруудын тайланг хөдөлмөрчид, үйлдвэр, албан газруудаар тавьж хөдөлмөрчдийн санал хүсэлтийг судлах.

10/X-ны дотор<br>Хотын худалдаа, нийтийн хоолны удирдах газар

4. Худалдаа, нийтийн хоолны үйлчилгээний байдал, Чихэр боовны үйлдвэр, Арьс ширний үйлдвэрийн нэгдэл, Оёдлын үйлдвэрийн нэгдэл, Хүүхдийн хувцас, саван, сүүний үйлдвэр, ногооны комбинатуудаас хөдөлмөрчдийн хэрэгцээнд нийлүүлж байгаа барааны чанар, төлөвлөгөөний биелэлт, аж ахуйн гэрээний сахилга хэрхэн биелэгдэж байгаад хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаа, худалдаа, аж үйлдвэрийн байнгын комиссын хамтарсан шалгалт хийх.

Ч.Жамбал<br>Дашдаваа<br>Султаан

5. 1982 оны бараа гүйлгээний төлөвлөгөөний биелэлт, 1983 оны захиалга нь хөдөлмөрчдийн эрэлт хэрэгцээг бүрэн хангаж байгаа эсэхэд судалгаа хийж тасалдаж байгаа буюу дутагдах барааны нэр төрлийг гаргаж хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээ боловсруулах.

15/X-ны дотор. Хотын ТЗ-ны төлөвлөгөөний комисс

Худалдаа удирдах газар

6.Худалдагч, кассчин, тогооч, үйлчлэгч нарын ажил мэргэжлийн сонгон шалгаруулах уралдааныг 3 шаттайгаар /дэлгүүр, гуанз, контор, трест, удирдах газар/ зохион явуулж шалгарагсадыг зөвлөлтийн худалдаа, нийтийн хоолтой хамтарсан уралдаанд оролцуулах.

20/Х-ны дотор.Худалдаа, нийтийн хоолны удирдах газар

7.Худалдаа, нийтийн хоолонд тэргүүн туршлага, дэвшилтэт хэлбэрийг нэвтрүүлж байгаа байдлыг шалгах туршлага эзэмшсэн ажилчин, бригад,тасаг, дэлгүүр, гуанзанд гэрчилгээ олгох, Хүнсний бараа 52,96-р дэлгүүрийг өөртөө үйлчлэх хэлбэрт оруулах.

Хотын худалдаа, нийтийн хоолны удирдах газар

8.Хүнсний ногоо борлуулах, ногоогоор амт чанар сайтай хоол хийх нэг сарын зохистой ажил зохиож дүгнэх.

Худалдаа, нийтийн хоолны удирдах газар

9.Худалдааны байгууллагын өр авлагыг барагдуулах ажил зохиож хотын худалдааны хэмжээгээр өр авлагыг хагас жилийнхээс %-иас доошгүй хувиар бууруулах, нийтийн хоолны газруудыг өргүй болгох арга хэмжээ авах.

Хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны санхүүгийн хэлтэс,
АХШ хороо, ШҮҮХ, худалдаа, нийтийн хоолны удирдах газар

10.Хотын хэмжээгээр дэлгүүр, гуанзуудаар хайрцаг, дэвтэр ажиллуулах, тусгай хүн томилон ажиллуулж хөдөлмөрчдийн эрэлт, хүсэлт, санал гомдлыг судлах хүлээн авах 15 хоногийн ажил зохиох дүгнэх.

Худалдаа, нийтийн хоолны удирдах газар

11.Дэлгүүр, гуанз, ресторан, агуулах зоорийн хүрэлцээ, байршилын схем гаргах, 1985,90 он хүртэл нэмж шинээр байгуулах судлагаа тооцоог гаргаж өргөтгөн байгуулах.

Хотын төлөвлөгөөний комисс
Худалдаа нийтийн хоолны удирдах газар

12.Худалдаа, нийтийн хоолны удирдах газруудаар үйлчилгээг хөнгөн шуурхай болгох талаар зохиож байгаа ажлын тайлан, цаашид сайжруулах талаар санал дүгнэлтийг гаргуулж авах.

15/Х.Рэнцэндаваа
Цагаан

13.Бараа,нийтийн хоолны нэр төрөл, чанар, хийцийн талаар үзэсгэлэн байгуулж хөдөлмөрчид болон депутатуудын санал дүгнэлт авах ажил зохиох.

20/Х Худалдаа
Нийтийн хоолны удирдах газар

## ХОЁР. Чуулганы бэлтгэлийг хангах техник зохион байгуулалтын ажлын талаар

I. Чуулганд тавих "Худалдаа, нийтийн хоолны үйлчилгээний чанар, соёлч байдлыг дээшлүүлэх талаар авах арга хэмжээний тухай илтгэл боловсруулан бэлэн болгох.

20/Х Л.Дугаржав, М.Шагдар, Д.Баатаржав

2. Худалдаа, нийтийн хоолны үйлчилгээ, хөдөлмөрчдийн хэрэгцээнд нийлүүлж байгаа барааны нэр төрөл чанарт байнгын комиссоос хийсэн шалгалтын дүнгийн тухай илтгэл бэлэн болгох.

25/Х Дашцаваа, Султаан, Шарав

3. Чуулганаас гарах тогтоолын төслийг боловсруулж бэлэн болгох, депутат, хөдөлмөрчдөөр хэлэлцүүлэх.

Ч.Жамбал, Дугаржав
I5/Х

4. Хотын АДХ-ын Ш чуулган дээр хотын доторхи автобусны үйлчилгээг сайжруулах талаар гаргасан депутатын асуулгын хариуг чуулганд оруулахаар бэлтгэх.

25/Х Дэмжид

5. Депутатуудын чуулганд бэлтгүүлж тойрогт нь ажиллуулж сонгогчидтой нь уулзалт хийлгэх.

20/Х. Районы АДХ-ын гүйцэтгэх захиргаа

6. Чуулганд депутат болон урилгаар суух хүмүүс, мөн үг хэлэх хүмүүсийн нэрсийг гаргаж урилга бичиж тараах.

25/Х. Р.Түмэндэмбэрэл
Б.Шарав

7. Хотын АДХ-ын зарим байнгын комиссын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудал боловсруулж бэлэн болгох.

25/Х. Р.Түмэндэмбэрэл, Б.Шарав

8. Чуулганы аж ахуйн бэлтгэл, зардлын тооцоог гаргаж байр, үйлчилгээ ий асуудлыг бэлэн болгох.

I5/Х. Жагардорж, Даваасамбуу

9. Чуулганаас зарим байнгын комисс, үйлдвэр аж ахуйн газарт өгөх бүтээлч ажлын даалгавар, депутатын асуулгыг бэлтгэх.

20/Х. Ч.Жамбал

I0. Хотын АДХ-ын I3 дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулганы шийдвэрийг хэрэгжүүлэн хөдөлмөрчдийн захидал мэдээлэл, эрэлт хүсэлтийг шийдвэрлэж барагдуулах талаар зохиож байгаа ажлын талаар чуулганд мэдээлэх сонсгол бэлтгэх.

Халтар

ЗОХИОН ЗААВАРЛАХ ...